



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 07 сарын 10 өдөр

Дугаар А/499

Арвайхээр

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох,
шууд гэрээ байгуулах эрх олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 34 дүгээр зүйлийн 34.1.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2019 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн 81 дүгээр дүгнэлтийн дагуу Боловсрол, соёл, спортын салбарын их засвар, тоног төхөөрөмж /Өвөрхангай, Хархорин, Зүүнбаян-Улаан, Бат-Өлзий, Уянга сум/ ажлын 11 дүгээр багц Уянга сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн гадна фасадны засвар, 13 дугаар багц Уянга сумын цэцэрлэгийн цэвэр усны шугамын гадна холболт зэрэг багцуудад оролцогч ороогүй тул хүчингүй болгосугай.

2. Дээрх хүчингүй болсон багцуудад гэрээ байгуулан, ажлын явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээж авахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-т даалгасугай.

ОРЛОГЧ



О.БАТЖАРГАЛ

011100872